

ЗАМ ТЭЭВЭР, ХАРИЛЦАА ХОЛБОО, ЭРЧИМ ХҮЧНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Т.АРИУНБОЛДЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин /2023 он/	Эхний хагас жил	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Аймгийн бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх”							
1.	1.1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тээвэр, авто зам, эрчим хүч, харилцаа холбооны салбарын чиглэлээр тусгах асуудлыг төлөвлөх, хэрэгжилтийг ханган ажиллах, тайлагнах.	Тээвэр, авто зам, эрчим хүч, харилцаа холбооны салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн хувь	88.7 хувь	Хэрэгжилт 50-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна.	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 5.10.1.Ухаалаг тээврийн системд тулгуурласан хотын доторхи нийтийн тээврийг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлж, тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангасан, өрсөлдөх чадвар бүхий аюулгүй, ая тухтай, зорчигч тээврийн үйлчилгээг үзүүлнэ, 5.10.2. Сурагчдын автобусны буудал болон хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн авто буудал	2024.01.02-2024.12.31	100%

2024

				байгуулж, зорчигч тээвэрлэлтийн аюулгүй байдал, үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд: 2024 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 15/04 дүгээр тогтоолоор 2022-2024 онд Орхон аймгийн "Авто тээврийг хөгжүүлэх" 4 зорилт 20 арга хэмжээ бүхий хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 16 арга хэмжээ бүхий ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Нийтийн тээврийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, ая тухтай байх ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 4.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15 ширхэг стандартын шаардлага хангасан дунд оврын автобусыг худалдан авч нийтийн тээврийн үйлчилгээний шинэ чиглэлүүдэд явуулж эхлээд байна. Ингэснээр 2021-2024 онд нийтийн тээврийн үйлчилгээнд 29 автобусаар парк шинэчлэлт хийгдсэнээр 79.1 хувь нь шинэчлэгдээд	
--	--	--	--	--	--

				байна. Аймгийн Засаг даргын А/597 дугаар захирамжаар Ч8: буюу "Даниста-Урд Хабитат-Дэнж-Уртын гол" чиглэл, А/620 дугаар захирамжаар Ч5: буюу "Хүлэг зах-Автовокзал-Говил" гэсэн чиглэлүүдийг тус тус баталсан. Шинээр батлагдсан Ч8, Ч5 чиглэлүүдэд 9 ширхэг автобусыг ХТГазарт хариуцуулан 2024 оны 07 дугаар сараас эхлэн нийтийн тээврийн үйлчилгээнд явуулж байна. 2024 оны байдлаар 7 чиглэлд 31 дунд оврын автобус үйлчилгээнд явж байна. Нийтийн тээврийн үйлчилгээнд цахим картын систем нэвтрүүлэх ажлын гүйцэтгэгчээр "Зэс арвид" ХХК шалгарч ажлыг эхлүүлснээр карт уншигч төхөөрөмж, хүн тоологч камер болон бусад дагалдах хэрэгслүүд, удирдлагын систем зэрэг 18 нэр төрлийн тоног төхөөрөмжийг нийлүүлэн ШУТП-д хүлээлгэн өгөөд байна. Нийтийн тээврийн төлбөрийн системийг үндэсний дата төвийн серверт суурилуулж, холболтын ажлын туршилт хийгдсэн. Смарт Эрдэнэт аппликейшний 2,0	
--	--	--	--	---	--

				хувилбарыг App store, Play store программын санд байршуулах хүсэлтийг программ эзэмшигчдэд илгээсэн. Одоогийн байдлаар Смарт Эрдэнэт аппликейшний шинэ хувилбар программын санд хянагдах, хэрэглэгчийн туршилт хийгдэх, автобусны карт хэвлүүлэх, бүх төрлийн банкны карт холбох зэрэг ажлууд хийгдэж байна. Тус ажилд орон нутгийн төсвийн 240.0 сая төгрөгийг төсөвлөсөн байна. Сурагчын болон нийтийн тээврийн автобусны зогсоол, буудал нэмэгдүүлэх, шинэчлэх ажлын хүрээнд Авто вокзалын өмнө 1, Эрх чөлөөний гудамжны хэсэгт /Цагдаагийн газрын урд/ 1, 2А хороололд 1, Жаргалант суманд 3, нийт 6 ширхэг стандартын шаардлага хангасан автобусны буудал, зогсоолыг ашиглалтад оруулсан бол Баянцагаан багт 1, Жаргалант суманд 4 автобусны буудлыг стандарт шаардлагад нийцүүлэн иж бүрэн засварласан. 2023-2024 онд улсын төсвийн 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар орон нутагт	
--	--	--	--	---	--

				зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн "Авто буудал"-ыг ашиглалтад авч үйл ажиллагааг эхлүүлээд байна. Тус Автобуудал нь 2480м.кв тайлбайтай, 4-н давхар / В1 давхартайгаа/ гадна авто зогсоол нь 7000м/кв талбайтай, 300 орчим тээврийн хэрэгслийн зогсоолын байгууламжтай, зорчигч тээвэрлэлтийн бүх үйлчилгээг нэг дор нэгтгэн үйл ажиллагаагаа явуулж байна.. 5.10.3.Аймгийн хэмжээнд хатуу хучилттай замын сүлжээ болон уулзваруудыг өргөтгөж, авто зам ашиглалтын үйлчилгээг сайжруулна зорилтийн хүрээнд: 2024 оны хөрөнгө оруулалтаар авто зам замын байгууламжийн 95 ажил төлөвлөсөнөөс орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 65 ажил, Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар 27 ажил, Жаргалант сумын хөрөнгө оруулалтаар 3 ажил тус тус хийхээр ажиллаж байна. Тус ажлуудаас гудамж хоорондыг 2 болон 3 мертэй замын 14 ажлын гэрээ батлагдан ажил	
--	--	--	--	--	--

				гүйцэтгэж эхэлсэн байна. 2024 оны хөрөнгө оруулалтаар авто зам замын байгууламжийн 95 ажлын гүйцэтгэл 51 хувьтайгаар үргэлжилж байна. Орон нутгийн төсвийн 8.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр 698м урт асфальтбетон хучилттай авто зам, замын байгууламж, 11 багийн 14 байршил 5.8 км авто замд их засвар шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулсан. 5.9.Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлнэ зорилтын хүрээнд: 2024 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 61, Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар 14, Жаргалант сумын хөрөнгө оруулалтаар 3 нийт 72 ажил хийхээр төвөлвөсөн байна. Үүнээс 77 ажилд захиалагчын хяналтын гэрээ хийгдэж хяналт тавин ажилласанаас нийт 75 ажилд улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан байна. байна.	
--	--	--	--	--	--

					9.1. Дэлхийн банкн төслөөр хэрэгжих Эрдэнэт хотын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хоёр тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэх, гэр хорооллын багуудын гудамж хоорондын цахилгааны модон тулгууруудыг төмөр бетонон шонгоор солих, цахилгааны шугамыг өргөтгөн шинэчлэх зорилтын хүрээнд: “ЭБЦТС” ТӨХК 15,043 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Эрчим хүчний төсөл-2 арга хэмжээ Орхон аймгийн 24000 хэрэглэгчийн тоолуурыг ухаалаг тоолуураар солих, 0,4 кВ-ын 260 км ЦДАШ -ыг төмөр бетон тулгуур, СИП утастай болгон шинэчлэх, цахилгаан хангамжийг сайжруулж хүчдэлийн уналттай байгаа хэрэглэгчдийг хэвийн хүчдэлээр хангах 9 иж бүрэн дэд станц барих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхээр РИЧВЕЛЛ ИНЖЕНЕРЕНГ ХХК ажиллаж байна. 2024 оны эцийн байдлаар барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл 96% -тай хэрэгжиж байна.	
2.	1.2.Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд	Тээвэр, авто зам, эрчим хүч,	81.1 хувь	Хэрэгжилт 50-аас доошгүй	Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн	100%

	тээвэр, авто зам, эрчим хүч, харилцаа холбооны салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ханган ажиллах.	харилцаа холбооны салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн хувь		ийн гүйцэтгэлтэй байна.	чиглэлд эрчим хүчний чиглэлээр 1, авто тээврийн чиглэлээр 4, агаарын тээврийн чиглэлээр 1 арга хэмжээг тусган 2024 оны хөрөнгө оруулалтын ажилд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023-2024 онд улсын төсвийн 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар орон нутагт зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн "Авто буудал"-ыг ашиглалтад авч үйл ажиллагааг эхлүүлээд байна. Тус Автобуудал нь 2480м.кв тайлбайтай, 4-н давхар / B1 давхартайгаа/, гадна авто зогсоол нь 7000м/кв талбайтай, 300 орчим тээврийн хэрэгслийн зогсоолын байгууламжтай, зорчигч тээвэрлэлтийн бүх үйлчилгээг нэг дор нэгтгэн үйл ажиллагаагаа явуулж байна. Авто буудал нь өдөрт хот хооронд, аймаг, сум хоорондын зорчигч тээвэрлэлт болон дамжин өнгөрч байгаа нийт 9 чиглэлийн 90-112 тээврийн хэрэгсэл, 1600-1800 зорчигч дамжин өнгөрүүлж байна. Мөн иргэдэд үзүүлэх үйлчилгээний шуурхай байдлыг хангах зорилгоор дараах	2024.01.02-2024.12.31	
--	---	---	--	--------------------------------	--	------------------------------	--

				байгууллагуудыг үйл ажиллагаа явуулах талбай болон албан өрөө тасалгаагаар хангаж, иргэдэд шаардлагатай үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай хүргэн, хамтран ажиллаж байна. Үүнд: Зорчигч тээврийн 7 байгууллага, Төрийн банк, Монгол шуудан үйлчилгээний газар, улсын дугаарын 2 үйлдвэр, даатгалын 7 байгууллага, авто үнэлгээний байгууллагууд тус тус байрлаж үйл ажиллагаа явуулж байна. Хаан банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банкуудын АТМ, Киоск төхөөрөмж, "Хурдан" гэрэгэ төхөөрөмжүүд суурилагдсан байна. 2. Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 4.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15 ширхэг стандартын шаардлага хангасан дунд оврын автобусыг худалдан авч нийтийн тээврийн үйлчилгээний шинэ чиглэлүүдэд явуулж эхлээд байна. Ингэснээр 2021-2024 онд нийтийн	
--	--	--	--	---	--

				тээврийн үйлчилгээнд 2 автобусаар парк шинэчлэлт хийгдсэнээр 79.1 хувь нь шинэчлэгдээд байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар нийтийн тээврийн үйлчилгээнд хөнгөлөлттэй зорчих иргэдийн нехөн олговорт 1589.0 төгрөгийг олгоод байна. 4. Орхон аймгийн цахилгаан хангамжийг дээшлүүлэх 35 кВ-ын тойрог схем үүсгэх ажлын зураг төслийг Бодит чадал ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар улсын экспертизид хянагдан баталгаажигдсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулахаар саналыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.		
3.	1.3.Аймгийг хөгжүүлэх 2024 оны жилийн төлөвлөгөөнд тээвэр, авто зам, эрчим хүч, харилцаа холбооны салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ханган ажиллах.	Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн хувь	96.7 хувь	Хэрэгжилт 50-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна. 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд авто тээврийн чиглэлээр 1 авто замын чиглэлээр 2, эрчим хүчний чиглэлээр 1 ажлыг тусган хэрэгжилтийн ханган ажиллаж байна. Үүнд: 1. Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх ажлын хүрээнд	2024.01.02-2024.12.31	100%

					орон нутгийн төсвийн 4. тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15 ширхэг стандартын шаардлага хангасан дунд оврын автобусыг худалдан авч нийтийн тээврийн үйлчилгээний шинэ чиглэлүүдэд явуулж эхлээд байна. Ингэснээр 2021-2024 онд нийтийн тээврийн үйлчилгээнд 29 автобусаар парк шинэчлэлт хийгдсэнээр 79.1 хувь нь шинэчлэгдээд байна. Орхон аймаг, Баян-Өндөр сумын 6 дугаар бичил хорооллын уулзвараас Их залуу багийн уулзвар хүртэлх А1002 дугаартай улсын чанартай авто замыг 4 эгнээ болгож өргөтгөн шинэчлэх ажлыг Шилдэг зам ХХК гүйцэтгэж байна. Жилийн эцсийн байдлаар суурийн болон далан, хөлдөлтөөс хамгаалах үе хийгдсэн. 2 байршилд нүхэн гарц хийгдсэн. Нийт ажлын гүйцэтгэл 80 орчим хувтай байна. Тус ажил 2025 онд үргэлжлэн хийгдэнэ.		
4.	1.4.Аймгийн хэмжээнд баримтлах салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, хөтөлбөр, төслийг хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй	Хөтөлбөр, төслийг хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулан	Холбогдох хөтөлбөр, төслийг боловсруулан хэрэгжүүлэн ажилласан.	Холбогдох хөтөлбөр, төслийг боловсруулан хэрэгжүүлэн	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04-р сарын 27-ны өдрийн 15/04 дүгээр тогтоолоор 2022-2024 онд Орхон аймгийн "Авто	2024.01.02-2024.12.31	100%

М

	уялдуулан боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах.	боловсруулан хэрэгжүүлнэ.		жилласан байна.	тээврийг хөгжүүлэх" зорилт 20 арга хэмжээ бүхий хөтөлбөрийг батлуулсан.		
5.	1.5.Төрийн захиргааны төв байгууллагаас салбарын чиглэлээр гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах	Төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан байна.	Салбарын чиглэлээр гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан.	Салбарын чиглэлээр гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан байна.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын 2018 оны 01 сарын 24-ны өдрийн 10-р тогтоолоор "Хотын доторхи замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам"-ыг батлуулан хэрэгжилтэд нь Автотээврийн төв, ЗЦТасаг, Авто замын хяналтын улсын байцаагч хяналт тавин ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар 25 иргэн 48 аж ахуй нэгж байгууллагад 311 ширхэг "С", "СЕ" зөвшөөрлийг олгож, 19,815,000 мянган төгрөгийг "Эрдэнэт сан"-д төвлөрүүлсэн байна.	2024.01.02-2024.12.31	100%
6.	1.6.Холбогдох байгууллагатай хамтран ажиллах ажлын төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, хүргүүлэх, тайланг нэгтгэх.	Холбогдох байгууллагатай хамтран ажиллах ажлын төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн тайлагнасан байна.	Ажлын төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн тайлагнасан.	Ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.	Аймгийн Засаг дарга Авто тээврийн үндэсний төвийн захирал нарын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан 24/39 дугаартай хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллан байна.	2024.01.02-2024.12.31	100%

					Мөн нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэж байгаа аж ахуй нэгж байгууллагаадтай байгуулсан зорчигч тээвэрлэх гэрээг улирал, жилээр дүгнэн хэрэгжилтийг хангуулж байна.		
7.	1.7.Аймгийн Засаг даргаас салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг нэгтгэн гаргаж тайланг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.	Аймгийн Засаг даргаас салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Гэрээний хэрэгжилтийг 90 хувиас дээш ханган ажилласан.	Гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах, тайлагнасан байна.	Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний хүрээнд аймгийн Засаг даргаас Зам тээврийн хөгжлийн яам, Эрчим хүчний яам, Цахим хөгжил, Харилцаа холбооны яамдын сайд нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийн хагас бүтэн жилээр гарган биелэлтийг 2025 онд хэрэгжүүлэх ажлын саналын хамт хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.	2024.01.02-2024.12.31	100%
Зорилт 2. “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах”							
1.	2.1.Тээвэр, авто зам, эрчим хүч, харилцаа холбооны салбарын чиглэлээр холбогдох захирамжийг гаргуулан ажиллах	Холбогдох захирамжийг гаргуулж, биелэлтэд хяналт тавин ажилласан хувь	100 хувь	100 хувь	Авто тээврийн чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2024 оны А/410 дугаар захирамжаар нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглагдах парк шинэчлэлтээр ирж байгаа автобуснуудын ашиглагчийг тодорхойлох, зохион байгуулалтын аргачлал бүхий ажлын хэсгийг байгуулан	2024.01.02-2024.12.31	100%

				ажиллаж байна. Нийтийн тээврийн үйлчилгээний парк шинэчлэлтээр ирсэн автобусуудыг Хот тохижуулах газар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж дуусгасан. Авто замын чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн А/295 тоот захирамжаар "Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулах" ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Захирамжийн хүрээнд 12 ажилд ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгосон байна. Эрчим хүч, харилцаа холбооны чиглэлээр: Аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлуудад техникийн нөхцөл үнэ төлбөргүй олгох аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/451 тоот захирамж гаргуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	
--	--	--	--	---	--

2	2.2. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангах	Үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан хувь	100 хувь	100 хувь	Аймгийн Засаг даргын шуурхай зөвөлгөөн болон Тамгын газрын шуурхай хурал, Удирдлагын шуурхай хурлаас өгөгдсөн 20 удаагийн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, хэрэгжилтийг тухай бүр И-Оффис программд тайлагнаж ажилласан	2024.01.02-2024.12.31	100%
Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”							
1.	3.1. Төрийн албан хаагчын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, холбогдох албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох газарт хүргүүлсэн.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох газарт хүргүүлсэн байна.	Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 01 дүгээр хавсралтаар баталсан “ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг үндэслэн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр боловсруулж, батлуулсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралтын дагуу ТЖАХ-ийн 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайлан”-г боловсруулж, мөн тушаалын 8 дугаар хавсралтын дагуу “Үнэлгээний хуудас”-аар	2024.01.02-2024.12.31	100%

					хэлтсийн дарга дүгнэ нэгжийн болон албан хаагчийн Үнэлгээг ТЗУХ- ийн хүний нөөцийн мэргэжилтэнд хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.		
2.	3.2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллана.	Зам, тээвэр, харилцаа холбоо, эрчим хүчний асуудлын хүрээнд 2023 оны баримт бичгүүдийн тайлан болон Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай байгуулсан Зам тээврийн хөгжлийн сайд, Эрчим хүчний сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын гэрээний тайланг гарган Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн архив, бичиг хэргийн эрхлэгчид жагсаалтын дагуу хүлээлгэн өгсөн.	2024.01.02- 2024.12.31	100%

Хоёр. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт/		
	1	2	3	4	5	6	7
1.	Шинээр батлагдсан хууль тогтоомжийг судалж, үйл	Үйл ажиллагаандаа	"Алсын хараа- 2050" Монгол	Шинээр батлагдан	Шинээр батлагдан	2024.01.02- 2024.12.31	100%

	ажиллагаандаа ашиглах, төрийн албаны тухай хуульд заасны дагуу багц сургалтад хамрагдсан байх	мөрдөн ажиллах сайжруулсан байна.	Улсын хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн эхний үе шат "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг зорилго зорилтыг төрийн албан хаагчдад таниулах сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.	гарсан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шаардлагатай хууль тогтоомжийг судалж үйл ажиллагаандаа мөрдлөг ажиллах	гарсан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шаардлагатай хууль тогтоомжийг судалж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.		
2.	Эрхэлсэн ажлын чиглэлээр холбогдох сургалтанд хамрагдах	Сургалтад хамрагдсан байх	Сургалтад хамрагдсан.	Сургалтад хамрагдсан байна.	- Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Ёс зүйн хорооны сургалтад хамрагдсан. - Аймгийн ЗДТГ-аас НҮБХХ-тэй хамтран зохион байгуулсан "Бодлогын баримт бичгийг үр дүнд суурилсан арга зүйгээр боловсруулах нь" сэдэвт 2 өдрийн сургалтад хамрагдаж өгөгдсөн	2024.01.02-2024.12.31	100%

				мэдээллийг бүрэн авч, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. • Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7*4*10 цахим сургалтад 20 удаа хамрагдсан. Үүнд: ТАЗ-өөс зохион байгуулсан : “Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагыг бэхжүүлэх нь”, “Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх эрх зүйн зохицуулалт, авч буй арга хэмжээ”, “Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”, “Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага”, “Ёс зүйн дэд хорооны		
--	--	--	--	---	--	--

					ажиллах журам"-ын танилцуулга, "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа", "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн танилцуулга, хэлэлцүүлэг сургалтуудад хамрагдсан.		
3.	Үндэсний бичгийн сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байх	Сургалтад хамрагдсан.	Сургалтанд хамрагдсан байна.	Байгууллагаас зохион байгуулж буй Үндэсний бичгийн сургалтад тухай бүр хамрагдаж байна.	2024.01.02-2024.12.31	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХБТХОХ-ИЙН ЗАМ ТЭЭВЭР, ХАРИЛЦАА ХОЛБОО,
ЭРЧИМ ХҮЧ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Т.АРИУНБОЛД